

“ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН АЛСЛАГДСАН СУМЫН БАГТ ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ
ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭХ”

ТӨСЛИЙН ТЕХНИК БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Төслийн зорилго

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутгийн алслагдсан сумын багийг хамарсан цэгт хөдөлгөөнт холбооны дэд бүтэц шинээр байгуулан 3G үйлчилгээг хүргэх зорилготой.

Хоёр.Төслийн хамрах хүрээ

Төслийн хүрээнд дараах нэр бүхий цэгт хөдөлгөөнт холбооны үйлчилгээг хүргэнэ.

№	Аймаг	Сум	Баг	Сайт тавих газрын нэр
1	Баянхонгор	Шинэжинст

Гурав. Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах техникийн тодорхойлолт болон шаардлага.

1. Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх.
-Тусгай зөвшөөрлын хуулбар
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх.
3. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага /ОУЦХБ/-ын зөвлөмж, стандартыг баримтална.
4. Сүлжээний ашиглалт, ажиллагааны байдлыг 24 цагаар хянах сүлжээ удирдлагын төвтэй, тогтвортой ажиллагааны түвшнийг хангасан байх.
6. Сүлжээний тодорхойлолт – Тендерт оролцогч санал болгож буй үйлчилгээ үзүүлэгчийн төлөвлөсөн сүлжээний тодорхойлолтыг гаргана.
7. Харилцан холболтын цэг. Оролцогч нь санал болгж буй үйл ажиллагааны эхний 2 жилд шаардагдах харилцан холболтын цэг, харилцан холболтын шугамын хэмжээ, тоог сайтар тооцоолсон байна. Оролцогч нь өөрийн сүлжээг өргөтгөх бүрд дээрх мэдээллийг өгч байна.

Дөрөв. Техникийн ерөнхий шаардлага.

- Шаардлагатай дамжуулах байгууламж болон үйлчилгээ үзүүлэх системийн технологийг хангах;
- Хэрэв сансрын холбоогоор дамжуулан үйлчилгээ хүргэх бол үйлчилгээний гэрээнд шаардагдах техникийн гүйцэтгэлийг харуулах
- Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээний хамрах хүрээ
- Холбогдох техникийн стандартыг баримтлах

Тав. Үйлчилгээний тодорхойлолт.

-Үйлчилгээ эрхлэгч нь гэрээний хугацаанд заавал үйлчилгээ эрхлэх бүс нутагт заавал үзүүлэх үйлчилгээг явуулна.

- Заавал үзүүлэх үйлчилгээг дараах хэлбэрээр тодорхойлно. Үүнд:

1) Үүрэн холбооны үйлчилгээнд орон нутаг, хот хооронд болон олон улсын орох, гарах ярианы үйлчилгээ орох ба доор дурдсан нөхцөл шаардлагын дагуу заавал үйлчилгээ үзүүлэх бүс нутагт явуулна.

а. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх бүс нутагт өөрийн техникийн шийдлийн дагуу дамжуулах болон холбох төхөөрмжийг сонгон үйлчилгээг эхэлсэн байна.

2) Үйлчилгээний тариф

а. Талууд өөрөөр тохиролцоогүй болон хууль эсхүл журамд өөрөөр заагаагүй бол үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зөвшөөрлийн хүрээнд гаргасан үйлчилгээний тарифыг мөрдлөг болгон үнийг тогтооно.

3) Найдвартай ажиллагаа

а. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний хугацаанд заавал үйлчилгээ хүргэх бүсэд тасралтгүй үзүүлэх нөхцөлийг хангана.

Зургаа. Үүрэг хүлээх хугацаа.

Үйлчилгээний найдвартай ажиллагааа, чанарын үзүүлэлтийн дагуу заавал үйлчилгээ үзүүлэх цэгүүдэд үйлчилгээг 12 сарын хугацаанд тогтмол, тасралтгүй хүргэнэ.